



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/014/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2025 он

МонголУлсын Ерөнхий аудиторын орлогч: Я.Самбууням  
Утас: 261663 Цахим хаяг: sambuunyam.ya@audit.mn  
Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: П.Чанцалдулам  
Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn  
Ахлах аудитор: Д.Мөнхжин  
Утас: 261740 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn  
Аудитор: О.Наранбат  
Утас: 261740 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД  
Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.04.25 № 1533  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,759.7 сая төгрөгөөр давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.3 дах заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Гадаад харилцааны сайд 6,000.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталж, гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас

7,968.7 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Ажлын алба байгуулах тухай” 124 дүгээр тогтоолоор Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын оролцогч Талуудын 17 дугаар Бага хурлыг 2026 онд Монгол Улсад зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах “Цөлжилттэй тэмцэх Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP-17)-ын бэлтгэл ажлын алба”-ыг Гадаад харилцааны яамны дэргэд байгуулсан байна. Тус арга хэмжээг зохион байгуулахтай холбоотой төсвийг Гадаад харилцааны сайдын багцад төсөвлөх хэрэгцээ шаардлага үүссэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Гадаад харилцааны яам нь тайлант онд Ерөнхийлөгчийн түвшинд 15, Улсын Их Хурлын даргын түвшинд 3, Ерөнхий сайдын түвшинд 8, Гадаад харилцааны сайдын түвшинд 8 айлчлал, Засгийн газар хоорондын комиссын 6 хуралдаан, Гадаад харилцааны яамд хоорондын 19 зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, сайдын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг 98.7 хувьтай хэрэгжүүлэн ажилласан талаар тус яамны Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар үнэлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-д заасны дагуу төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гарган өгч, мэдээллээр бүрэн хангаж ажилласан.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is written in a cursive style, crossing the stamp.

Д.ЗАГДЖАВ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>16,955,798.3</b>	<b>20,083,078.4</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,072,982.5	9,064,780.2
33	АВЛАГА	3,891,585.1	4,224,779.3
34	УРЬДЧИЛГАА	1,264,607.7	1,014,274.3
35	БАРАА МАТЕРИАЛ	5,726,623.0	5,779,244.6
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>502,364,864.5</b>	<b>515,118,640.2</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	502,364,864.5	515,118,640.2
39100	Газар	45,966,490.4	46,095,332.2
39200	Биет хөрөнгө	414,861,213.2	423,278,451.7
39300	Биет бус хөрөнгө	41,537,160.9	45,744,856.3
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>519,320,662.8</b>	<b>535,201,718.6</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,888,089.3</b>	<b>3,736,120.8</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,245,484.2	3,148,680.6
41300	Өглөг	1,219,865.4	3,137,164.4
41400	Урьдчилж орсон орлого	25,618.8	11,516.2
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	642,605.2	587,440.2
42200	Урт хугацаат зээл	642,605.2	587,440.2
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>517,432,573.4</b>	<b>531,465,597.8</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	517,432,573.4	531,465,597.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	208,458,183.0	208,458,183.0
51200	Хуримтлагдсан үр дүн	(101,884,316.1)	(96,981,906.2)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	260,991,667.5	265,290,034.0
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	149,867,039.0	154,699,287.1
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>519,320,662.8</b>	<b>535,201,718.6</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>182,229,747.8</b>	<b>227,108,681.5</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,179,344.0	17,053,269.4
120	Нийтлэг татварын бус орлого	19,179,344.0	17,053,269.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	163,050,403.7	210,055,412.1
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>197,928,321.5</b>	<b>226,055,824.7</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	197,928,321.5	217,231,292.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	143,980,064.2	162,346,216.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,392,654.3	57,586,150.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,498,945.0	2,614,926.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,690,020.9	25,524,512.40
2104	Хангамж, бараа материалын зардал	3,131,169.5	3,383,183.60
2105	Нормативт зардал	23,070.4	16,037.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,944,856.6	1,814,695.10
2107	Томилолт, зочны зардал	8,492,183.2	18,600,408.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,662,472.5	24,361,091.20

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,144,691.9	28,445,210.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,948,257.3	54,885,076.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	8,824,531.7
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(15,698,573.8)</b>	<b>1,052,856.8</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>142,950.8</b>	<b>503,490.8</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>56,958.0</b>	<b>599,701.9</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(15,612,581.1)</b>	<b>956,645.7</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>189,307,547.1</b>	<b>233,839,374.8</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,241,435.0	23,011,783.3
120	Нийтлэг татварын бус орлого	21,241,435.0	23,011,783.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	168,066,112.1	210,827,591.5
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>183,994,068.8</b>	<b>210,418,185.3</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	183,994,068.8	210,418,185.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	129,777,397.1	147,885,804.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,382,091.6	58,980,736.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,042,879.8	3,202,071.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,357,895.6	28,142,149.7
2104	Хангамж, бараа материалын зардал	4,351,132.1	4,397,996.8
2105	Нормативт зардал	35,343.3	31,998.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,297,237.4	1,789,834.9
2107	Томилолт, зочны зардал	8,474,442.4	18,134,838.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,978,681.8	23,479,996.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,857,693.1	9,726,182.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,216,671.8	62,532,381.0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>5,313,478.2</b>	<b>23,421,189.5</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>265,619.8</b>	<b>588,157.9</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>6,445,059.0</b>	<b>20,841,390.8</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,445,059.0	20,841,390.8
2200	Дотоод эх үүсвэрээр	6,445,059.0	20,841,390.8
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(6,179,439.2)</b>	<b>(20,253,233.0)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(853,453.3)</b>	<b>(176,158.8)</b>
14	Бусад эх үүсвэр	-	108,491.8
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	853,453.3	284,650.7
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>(1,719,414.3)</b>	<b>2,991,797.7</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,792,396.8	6,072,982.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,072,982.5	9,064,780.2

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>1</b>	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>546,108,856.7</b>	-	<b>546,108,856.7</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	521,784.5	-	521,784.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	546,630,641.2	-	546,630,641.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(1,149,177.2)	-	(1,149,177.2)
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	(12,166,005.4)	-	(12,166,005.4)
8	Зарласан ногдол ашиг	(270,304.2)	-	(270,304.2)
9	Тайлант үеийн үр дүн	(15,612,581.1)	-	(15,612,581.1)
<b>10</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>517,432,573.4</b>	-	<b>517,432,573.4</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	60,922.9	-	60,922.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	517,493,496.4	-	517,493,496.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	4,298,366.5	-	4,298,366.5
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	4,832,248.1	-	4,832,248.1
18	Зарласан ногдол ашиг	(90,043.0)	-	(90,043.0)
19	Тайлант үеийн үр дүн	956,645.7	-	956,645.7
<b>20</b>	<b>2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>531,465,597.8</b>	-	<b>531,465,597.8</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>207,047,052,300.00</b>	<b>152,471,242,484.33</b>	<b>54,575,809,815.67</b>	<b>73.6</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>193,347,052,300.00</b>	<b>139,089,926,500.10</b>	<b>54,257,125,799.90</b>	<b>71.9</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>186,968,172,200.00</b>	<b>136,362,625,010.77</b>	<b>50,605,547,189.23</b>	<b>72.9</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>73,041,149,300.00</b>	<b>55,570,468,319.90</b>	<b>17,470,680,980.10</b>	<b>76.1</b>
Үндсэн цалин	68,705,649,300.00	51,888,491,778.81	16,817,157,521.19	75.5
Нэмэгдэл	3,105,458,600.00	2,678,923,889.78	426,534,710.22	60.0
Унаа хоолны хөнгөлөлт	531,578,400.00	440,993,114.46	90,585,285.54	83.0
Урамшуулал	698,463,000.00	562,059,536.85	136,403,463.15	80.5
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2,686,615,200.00</b>	<b>2,525,549,078.64</b>	<b>161,066,121.36</b>	<b>94.0</b>
Тэтгэврийн даатгал	2,408,978,200.00	2,270,614,511.75	138,363,688.25	94.3
Тэтгэмжийн даатгал	69,409,300.00	65,245,699.07	4,163,600.93	94.0
ҮОМШӨ-ний даатгал	34,704,500.00	32,181,323.83	2,523,176.17	92.7
Ажилгүйдлийн даатгал	34,704,700.00	31,458,083.49	3,246,616.51	90.6
Эрүүл мэндийн даатгал	138,818,500.00	126,049,460.50	12,769,039.50	90.8

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>32,502,600,900.00</b>	<b>25,009,925,051.88</b>	<b>7,492,675,848.12</b>	<b>76.9</b>
Гэрэл, цахилгаан	2,517,660,100.00	1,507,639,330.64	1,010,020,769.36	59.9
Түлш, халаалт	2,746,258,200.00	1,645,484,330.26	1,100,773,869.74	59.9
Цэвэр, бохир ус	1,101,272,700.00	670,411,472.95	430,861,227.05	60.9
Байрны түрээс	26,137,409,900.00	21,186,389,918.03	4,951,019,981.97	81.1
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,835,367,500.00</b>	<b>3,286,023,073.58</b>	<b>1,549,344,426.42</b>	<b>68.0</b>
Бичиг хэрэг	661,534,600.00	379,489,094.79	282,045,505.21	57.4
Тээвэр, шатахуун	2,027,515,500.00	1,460,027,265.15	567,488,234.85	72.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,512,772,500.00	962,896,879.65	549,875,620.35	63.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	139,762,400.00	25,988,709.33	113,773,690.67	18.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	493,782,500.00	457,621,124.66	36,161,375.34	92.7
<b>Нормативт зардал</b>	<b>113,886,900.00</b>	<b>29,529,794.35</b>	<b>84,357,105.65</b>	<b>25.9</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	113,886,900.00	29,529,794.35	84,357,105.65	25.9
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,235,003,600.00</b>	<b>3,408,587,125.23</b>	<b>2,826,416,474.77</b>	<b>54.7</b>
Багаж, техник, хэрэгсэл	2,759,358,300.00	1,678,324,206.67	1,081,034,093.33	60.8
Тавилга	407,500,000.00	161,604,058.77	245,895,941.23	39.7
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	24,758,000.00	-	24,758,000.00	-
Урсгал засвар	3,043,387,300.00	1,568,658,859.79	1,474,728,440.21	51.5
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>25,391,355,700.00</b>	<b>17,562,074,061.48</b>	<b>7,829,281,638.52</b>	<b>69.2</b>
Гадаад албан томилолт	12,987,278,700.00	8,142,726,175.25	4,844,552,524.75	62.7
Дотоод албан томилолт	43,771,600.00	19,302,072.00	24,469,528.00	44.1
Зочин төлөөлөгч хүлээн авах	12,360,305,400.00	9,400,045,814.23	2,960,259,585.77	76.1
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>30,163,539,400.00</b>	<b>22,101,334,492.56</b>	<b>8,062,204,907.44</b>	<b>73.3</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,887,766,500.00	8,336,026,253.47	2,551,740,246.53	76.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,943,000.00	2,943,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	17,964,012,000.00	12,933,857,800.50	5,030,154,199.50	72.0
Тээврийн хэрэгслийн татвар	215,800.00	181,857.00	33,943.00	84.3
Тээврийн хэрэгслийн оношлогоо	68,700.00	-	68,700.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	668,916,200.00	502,103,074.69	166,813,125.31	75.1
Газрын төлбөр	136,272,900.00	89,320,922.50	46,951,977.50	65.5
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	503,344,300.00	236,901,584.40	266,442,715.60	47.1
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,998,653,700.00</b>	<b>6,869,134,013.15</b>	<b>5,129,519,686.85</b>	<b>57.2</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	5,548,165,400.00	3,106,740,763.47	2,441,424,636.53	56.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,450,488,300.00	3,762,393,249.68	2,688,095,050.32	58.3
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,378,880,100.00</b>	<b>2,727,301,489.33</b>	<b>3,651,578,610.67</b>	<b>42.8</b>

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>4,858,265,800.00</b>	<b>2,261,199,862.38</b>	<b>2,597,065,937.62</b>	<b>46.5</b>
Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,858,265,800.00	2,261,199,862.38	2,597,065,937.62	46.5
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,520,614,300.00</b>	<b>466,101,626.95</b>	<b>1,054,512,673.05</b>	<b>30.7</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	524,699,900.00	331,755,968.00	192,943,932.00	63.2
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	897,833,800.00	63,677,659.00	834,156,141.00	7.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	98,080,600.00	70,667,999.95	27,412,600.05	72.1
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>13,700,000,000.00</b>	<b>13,381,315,984.23</b>	<b>318,684,015.77</b>	<b>97.7</b>
Их засвар	6,300,000,000.00	6,199,025,995.00	100,974,005.00	98.4
Тоног төхөөрөмж	7,400,000,000.00	7,182,289,989.23	217,710,010.77	97.1
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>207,047,052,300.00</b>	<b>155,936,052,574.45</b>	<b>51,110,999,725.55</b>	<b>75.4</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>206,147,052,300.00</b>	<b>154,768,682,196.32</b>	<b>51,378,370,103.68</b>	<b>75.1</b>
Улсын төсвөөс санхүүжих	206,147,052,300.00	154,768,682,196.32	51,378,370,103.68	75.1
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>900,000,000.00</b>	<b>1,167,370,378.13</b>	<b>(267,370,378.13)</b>	<b>129.7</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	900,000,000.00	1,167,370,378.13	(267,370,378.13)	129.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	915,163,361.20	(915,163,361.20)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,513,908,686.32	(3,513,908,686.32)	-
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>1,443</b>	<b>1,413</b>	<b>30</b>	<b>97.9</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>55</b>	<b>55</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Төсвийн байгууллага	55	55	-	100.0
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>694</b>	<b>679</b>	<b>15</b>	<b>97.8</b>
Удирдах ажилтан	62	86	(24)	138.7
Гүйцэтгэх ажилтан	410	385	25	93.9
Үйлчлэх ажилтан	222	208	14	93.7

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>-</b>	<b>10,248,738,967.03</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	8,804,883,528.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	7,659,398,715.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	1,089,668,675.00
210101	Үндсэн цалин	-	1,089,668,675.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	836,884,380.00
210301	Гэрэл, цахилгаан	-	11,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	8,000,000.00
210304	Байрны түрээс	-	817,384,380.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	132,565,750.00
210401	Бичиг хэрэг	-	67,737,500.00
210402	Тээвэр, шатахуун	-	24,250,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	40,578,250.00
2105	Нормативт зардал	-	2,468,730.00
210502	Хоол, хүнс	-	2,468,730.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	76,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	24,500,000.00

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210604	Урсгал засвар	-	52,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	572,764,047.00
210701	Гадаад албан томилолт	-	528,626,047.00
210702	Дотоод албан томилолт	-	138,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	44,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,283,445,817.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,222,845,817.54
210803	Даатгалын үйлчилгээ	-	59,000,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	1,600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,665,101,316.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,540,101,316.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	125,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,145,484,812.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	784,766,361.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	784,766,361.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	360,718,451.27
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	360,718,451.27
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,443,855,439.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,443,855,439.00
222001	Тоног төхөөрөмж	-	1,105,069,680.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	338,785,759.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>10,248,738,967.03</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	10,248,738,967.03
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,296,478,667.03
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,477,925,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,474,334,400.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

#### 3.1 Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн, алдаа зөрчил

Аудитаар санхүүгийн тайлантай холбоотой нийт 22.6 сая төгрөгийн 2 алдаа илэрснээс аудитын явцад бүрэн залруулж, 3,100.5 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага хүргүүлж, 1,930.1 сая төгрөгийн зөрчилд 12 зөвлөмж өгсөн байна.

##### 3.1.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP-17)-ын бэлтгэл ажлын албаны даргын 2024 оны А/03, А/06, А/07, А/08, А/09, А/10, А/11, А/12, А/13 дугаар тушаалаар гадаад албан томилолтын зардлыг батлахдаа Сангийн сайдын 2011 оны "Гадаад албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" 188 тушаалаар баталсан зардалд тусгагдаагүй 2.1 сая төгрөгийн нисэх-буудал-нисэх явах зардал, 1.7 сая төгрөгийн харилцаа холбооны зардлыг төсөвлөж, нийт 32.6 сая төгрөгийн зам хоног, зочид буудлын зардлыг илүү олгосон байна. Үүнээс, 13.4 сая төгрөгийг томилолтын тооцоогоор буцаан шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-г "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан "Гадаад оронд болох хурал, зөвлөгөөн, уулзалт, яармагт оролцох, гэрээ хэлэлцээр хийх, туршлага судлах зэрэг ажлаар гадаад оронд явагчдын гадаад албан томилолтын зам, хоног, зочид буудлын зардлын хэмжээ"-г мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан "Гадаад албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" журамд заасан зардлын нормативыг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

##### 3.1.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Цөлжилттэй тэмцэх нэгдсэн конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP-17)-ын бэлтгэл ажлын алба нь Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй нийт 41.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-д заасан "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ", 46 дугаар зүйлийн 46.1-д "Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, гүйцэтгэлийг тайлагнаж байх

Илрүүлэлт 2: Монгол Улс, ОХУ хоорондын улсын хилийг шалгах Монгол Оросын хамтарсан комисс нь тайлант онд худалдаж авсан 694.0 сая төгрөгийн 3 тээврийн хэрэгслийн

ашиглагдах жилийг бүртгэлд тусгахдаа байгууллагын НБББББ-т заасан ашиглагдах жилээс зөрүүтэй бүртгэсэн байна.

Энэ нь ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллах НБББББ-ийн Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ 3.1-т “Ачааны, суудлын автомашин, микробус, автобус - 5 жил” гэж заасантай нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг шинээр бүртгэлд тусгахдаа НБББББ-т заасан ашиглагдах жилээр бүртгэж байх, 3 тээврийн хэрэгслийн ашиглагдах жилийг бүртгэлд НБББББ-т заасан ашиглагдах жилээр залруулан бүртгэх.

### 3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

#### 3.2.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, Гадаад харилцааны сайдын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт зөрчил нь 5,030.6 сая төгрөг болж, өмнөх оноос 4,616.3 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.3-т Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Зөвлөл Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын санхүүгийн нийт зөрчлийн дүнг 30 хувиар бууруулж ажиллах, албан шаардлага хүргүүлэв.

#### 3.2.2 Зөвлөмж

##### 1.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой дараах асуудлууд илэрлээ. Үүнд:

- Төсвийн төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй уялдуулж, үндэслэлтэй боловсруулаагүй, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 245 дугаар тогтоолоор ГХС-ын төсвийн төслийн зарлагын дээд хязгаарыг 161,290.1 сая төгрөгөөр баталсан боловч төсвийн төсөлд нийт зарлагыг 231,506.6 сая төгрөгөөр тооцон төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн. ГХС-ын урсгал зардлын батлагдсан төсөв 193,347.1 сая төгрөг, гүйцэтгэл 139,089.9 сая төгрөг буюу 73.6 хувьтай байна.

- Нийт 50 ДТГ-уудаас 38 ДТГ нь туслах үйл ажиллагааны орлого төлөвлөөгүй, туслах үйл ажиллагаанаас 2,380.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 27 дугаар зүйлийн 27.1-д "Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана", 27.1.2-т "Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх", 27.1.4-т "жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн төлөвлөгөөг Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн, жилийн төсвийн хязгаартай уялдуулж үндэслэлтэй боловсруулж байх.

## 2. Хөрөнгө оруулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд ГХЯ нь өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтгүй, ДБҮЭГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1-р байр архивын барилга байгууламжид 288.2 сая төгрөгөөр их засвар хийж, хөрөнгөөр бүртгэсэн байна. Тайлангийн өдрийн дараах үйл явдал буюу Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 90 дугаар тогтоолоор ДБҮЭГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тус барилгыг ГХЯ-ны үндсэн хөрөнгөд балансаас балансад шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа ГХЯ-ны барилга байгууламжид бүртгэсэн хөрөнгөд капиталжуулж, үнэн зөв бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 22.6 сая төгрөгийн 5 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Гадаад харилцааны яам	1	11.8			1	11.8	1	11.8				
ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс	4	10.8			4	10.8	4	10.8				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>22.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>5</b>	<b>22.6</b>	<b>5</b>	<b>22.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Аудитаар нийт 5,030.6 сая төгрөгийн 26 зөрчил илэрснээс, 3,100.6 сая төгрөгийн 12 албан шаардлага хүргүүлж, 1,930.0 сая төгрөгийн 14 зөвлөмж өгсөн.

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Гадаад харилцааны сайд	3	-			1	-	2	-				
Гадаад харилцааны яам	6	67.7			1	38.6	5	29.1				
Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар	6	44.7			5	33.9	1	10.8				
Дипломат төлөөлөгчийн газар	6	4,848.2			3	3,001.1	3	1,847.1				
ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс	2	5.5			1	4.1	1	1.4				
Монгол Улс, ОХУ хоорондын улсын хилийг шалгах Монгол Оросын хамтарсан комисс	1	-					1	-				
Цөлжилттэй тэмцэх нэгдсэн конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP-17)-ын бэлтгэл ажлын алба	2	64.5			1	22.9	1	41.6				
<b>Дүн</b>	<b>26</b>	<b>5,030.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>12</b>	<b>3,100.6</b>	<b>14</b>	<b>1,930.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 202.6 сая төгрөгийн 6 зөрчил илэрснээс 190.1 сая төгрөгийн 3 албан шаардлага, 12.5 сая төгрөгийн хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*/сая төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой</b>													
Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар	1	14.4			1	14.4							
ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс	1	-			1	-							
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>14.4</b>	-	-	<b>2</b>	<b>14.4</b>	-	-	-	-	-	-	-
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>													
Гадаад харилцааны яам	2	-					2	-					
Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар	2	188.2			1	175.7			1	1	12.5		
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>188.2</b>	-	-	<b>1</b>	<b>175.7</b>	<b>2</b>	-	<b>1</b>	<b>1</b>	<b>12.5</b>	-	-
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>202.6</b>			<b>3</b>	<b>190.1</b>	<b>2</b>	-	<b>1</b>	<b>1</b>	<b>12.5</b>	-	-